



ОРХОН АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧИЙН ТОГТООЛ

2016 оны 11 сарын 28 өдөр

Дугаар 132

Эрдэнэт

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3 дахь заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймгийн нутаг дэвсгэрт сүм, хийд, шашны байгууллага байгуулж, үйл ажиллагаа явуулах журмыг шинэчлэн боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтын ёсоор баталсугай.

2. Аймгийн нутаг дэвсгэрт сүм, хийд, шашны байгууллага байгуулж, үйл ажиллагаа явуулах журмыг шинэчлэн боловсруулж, төслийг 2016 оны 12 дугаар сард багтаан Тэргүүлэгчдийн Хуралд оруулж хэлэлцүүлэхийг ажлын хэсгийн ахлагч /Б.Оюунбаяр/-т даалгасугай.

ДАРГА  П. ПҮРЭВЛХАГВА



АЙМГИЙН НУТАГ ДЭВСГЭРТ СҮМ, ХИЙД, ШАШНЫ БАЙГУУЛЛАГА  
БАЙГУУЛЖ, ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛАХ ЖУРМЫГ ШИНЭЧЛЭН  
БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч:	Б.Оюунбаяр	-Аймгийн ИТХ-ын Төлөөлөгч, Эрх зүй, нутгийн удирдлагын хөгжлийн хорооны дарга
Гишүүд:	Ц.Алтаншагай	- Аймгийн ИТХ-ын Төлөөлөгч, Эрх зүй, нутгийн удирдлагын хөгжлийн хорооны гишүүн
	Г.Эрдэнэбат	- Аймгийн ИТХ-ын Төлөөлөгч, Эрх зүй, нутгийн удирдлагын хөгжлийн хорооны гишүүн
	Д.Ууганбаяр	- Аймгийн ИТХ-ын Төлөөлөгч, Эрх зүй, нутгийн удирдлагын хөгжлийн хорооны гишүүн
	Г.Гантөгс	- Аймгийн ЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн
	В.Энхбат	- Тагнуулын газрын шашин сүм хийд хариуцсан ажилтан
	Б.Өлзийжаргал	- БСУГ-ын Бодлого, төлөвлөлт, хууль тогтоомжийн хэрэгжилт хариуцсан ахлах мэргэжилтэн
	Л.Батцэцэг	-Улсын бүртгэлийн хэлтсийн хуулийн этгээдийн улсын бүртгэгч
Д.Ганбат	- Цагдаагийн газрын шашин, сүм, хийд хариуцсан эрүүгийн ахлах байцаагч	